

“БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


“Булл Капитал ББСБ” ХХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны нэгдсэн тайланг хүргэж байна. Хэдийгээр тухайн жилд зах зээлийн нөхцөл байдал таагүй байсан ч манай компани Бизнес төлөвлөгөөнийхөө дагуу тавьсан зорилго, зорилтуудаа хангахын тулд нөөц бололцоогоо дайчлан ажиллалаа.

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	2025 оны 1-р сард компанийн 2024 оны Санхүүгийн тайлан, гүйцэтгэлийг хэлэлцэж, нийт ажилтнуудын хэмжээнд үр дүнгийн хурал зохион байгуулсан.
2	Компанийн ТУЗ-өөр эцэслэн батлагдсан 2025 оны Төсвийн төлөвлөгөөний дагуу бүх нэгжүүдэд төлөвлөгөөний хуваарилалт 2025 оны 1 сард хийгдсэн.
3	Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Nexia Mongolia Audit” LLC-аар хөндлөнгийн аудит хийлгэж, баталгаажуулан Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны болон компанийн вэбсайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн.
4	2025 оны 3-р сард Биржийн бус захаас татан төвлөрүүлсэн 5.8 тэрбум төгрөгийн дүнтэй “Булл бонд 4”-ыг үндсэн дүн, хүүний хамт төлж хаасан бол 2025 оны 3-р сард “Булл бонд 5”-ын 3 дахь транч 3.9 тэрбум төгрөгийн бонд, мөн 12.0 тэрбум төгрөгийн дүнтэй “Булл бонд 6” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 9-р сард 6.5 тэрбум төгрөгийн дүнтэй бондыг тус тус Биржийн бус зах дээр амжилттай гаргасан.
5	Тухайн жилд санхүү, мөнгөн урсгалын зөв төлөвлөлтийг хийж ажилласнаар Санхүүгийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчид, Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.
6	Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 12 ажилтан шинээр нэмж, 8 ажилтан албан тушаал дэвшиж нийт үндсэн ажилтны тоо 50 болсон.
7	2024 он болон 2025 оны эхний хагас жилийн компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр салбартаа тэргүүлэгч байр сууриа дахин баталсан.
8	18.0 тэрбум төгрөгийн дүнтэй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажлын хүрээнд СЗХ-оос Тусгай зориулалтын компани байгуулах зөвшөөрлийг 2025 оны 7 сарын 24-ний өдөр, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх зөвшөөрлийг 2025 оны 12 сарын 11-ний өдөр тус тус авсан ба 2026 оны 01 сарын 12-ны өдөр анхдагч арилжааг Хөрөнгийн бирж дээр эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
9	Тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийн бүтцийг сайжруулах, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор Олон улсын хөрөнгө оруулалтын сангаас нэмж 1.9 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.
10	Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 3-р сард Улаанбаатар хотын төвийн бүсэд

	“Төв салбар” болон “Рокмон салбар” -уудыг шинээр нээсэн. Харин зах зээлийн боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 12-р сард Сансар салбарын байршлыг өөрчилж, Нарантуул, Дүнжингарав худалдаа үйлчилгээний төвүүдэд ойртуулан, Баянзүрх салбар нэртэйгээр илүү нээлттэй зах зээлд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.
11	2025 оны 4, 7, 11-р сард СЗХ-оос гүйцэтгэсэн газар дээрх хяналт шалгалтад хамрагдаж хангалттай үнэлгээ авсан.
12	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд нийт 65 удаа хуралдаж, тус тусын хороодод хамаарах асуудал бүрийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Тэдгээрээс онцолвол 2025 оны 8-р сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Х.Амгаланбаатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлж ТУЗ-ийн даргаар, ТУЗ-ийн дарга С.Ганбаатарыг ердийн гишүүнээр тус тус томилсон.
13	2025 оны 09-р сарын 01-ний өдрөөс 2011 оноос эхлэн Худалдаа хөгжлийн банканд эдийн засагч, ахлах эдийн засагч, менежер, салбарын захирал, “Инвескор ББСБ”ХК-д Газрын захирал, 2021 оноос “Булл капитал ББСБ”ХХК-д Газрын захирлаар ажиллаж, Банк, санхүүгийн салбарт арвин мэдлэг, туршлага хуримтлуулсан О.Даваанямыг компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр Гүйцэтгэх захирлаар томилон ажиллуулж байна. Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын шалгуур: a. Цалингийн хувьд Компанийн цалингийн матрицад батлагдсан Гүйцэтгэх захиралд олгох цалингийн хэмжээгээр тооцно; b. Урамшууллын хувьд тухайн жилд ТУЗ-өөр эцэслэн батлагдсан компанийн төсвийн төлөвлөгөөнд заасан Цэвэр ашгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувь болон түүнээс дээш хувиар давуулан биелүүлсэн тохиолдолд үндсэн цалингийн хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, харин цэвэр ашгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувиас доош бол нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр тооцохоор зааж түүнтэй байгуулсан Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээнд тусгасан.
Эрсдэлийн удирдлага:	
14	Гадаад орчин дахь эдийн засаг, зах зээл, зохицуулалтын өөрчлөлтийг тогтмол хянан, эрсдэлийг урьдчилан тооцож зохих арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн компанийн бодлого, журмуудыг үнэлж, шаардлагатай өөрчлөлт, шинэчилсэн бодлого, журмыг боловсруулан баталсан.
15	Санхүүгийн эрсдлийг бууруулах зорилгоор давхар болон дараалсан хяналтын системийг нэвтрүүлж, хөрвөх чадварыг хангахын тулд мөнгөн урсгалыг тогтмол төлөвлөж ажилласан. Үүнээс гадна, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан Санхүүгийн удирдлага, хяналтын газар долоо хоног бүр мөнгөн урсгалын хяналт хийж, Эрсдэлийн нэгж зээлийн эрсдэлийг өдөр бүр хянан ажилласан.
	Улирал бүр Эрсдэлийн тайланг ТУЗ-ийн эрсдэлийн хороонд танилцуулж холбогдох

16	шийдвэрийг гаргуулан, хэрэгжүүлж ажилласан. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь эрсдэлийн төрөл, хэмжээ, хязгаарыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн нийт 25 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд: ➤ Эрсдэлийн тайланг улирал бүр хэлэлцэн, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. ➤ Их хэмжээний хэлцэл хийхтэй холбогдуулан эрсдэлд дүгнэлт гаргаж, нийт 22 шийдвэрийг хэлэлцэн баталсан. Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд улирал бүр Санхүү, хууль, эрсдэл, комплаенс, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгжүүдээс холбогдох тайлан, мэдээнүүдийг авч хэлэлцэн, зохих үүрэг чиглэлийг өгч, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Гүйцэтгэх удирдлага, эрсдэл хариуцсан нэгжид зохих зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь тайлант хугацаанд нийт 3 удаа, 100 хувийн ирцтэйгээр хуралдсан. Хороо нь Дотоод аудитын хэлтсийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шууд удирдлагаар хангаж ажилласан. Дотоод аудитын хэлтэс нь төлөвлөгөөт 3 аудит (<i>салбарын аудит 2, төвийн нэгжийн 1</i>) тусгай аудит 2 нийт 5 аудитыг газар дээр болон зайнаас хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор тайлант хугацаанд 3 удаагийн эргэн хяналтын тайлан. Мөн нэгжийн эргэн хяналтын тайлангаар хэрэгжээгүй болон хагас хэрэгжсэн тайланг эргэн хэлэлцэх зорилгоор 3 удаагийн улирлын тайланг бэлтгэн ажилласан байна. Мөн 2025 онд хийгдсэн их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийх хэлцлийн талаар санал, дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн. Мөн Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлуулсан ба Хувьцаа эзэмшигчиддээ танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан.
17	Мэдээллийн аюулгүй байдлын хэвийн үйл ажиллагааг хангах, нууцлалыг хамгаалах, мэдээллийн системийн хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор тогтмол хяналт тавьж, сайжруулалт хийн ажилласан байна.
18	“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” чиглэлийн тоон болон чанарын шаардлагыг хангах зорилгоор сургалт, судалгааг тогтмол зохион байгуулсан. Мөн Банк, санхүүгийн академийн сертификат олгох сургалтад нийт зээлийн эдийн засагчид болон төвийн нэгжийн ажилтнууд амжилттай хамтрагдан сертификат авсан.
19	Комплаенсын эрсдэлийг бууруулах зорилгоор үйл ажиллагаандаа “Улс төрд нөлөө бүхий этгээд”-ийг танин баталгаажуулах Монпеп системийг нэвтрүүлсэн.

20	“Харилцагчийг хамгаалах бодлого”-ыг шинээр, “Эрсдэлийн удирдлагын бодлого”, “Зээлийн бодлого”-уудад холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.	
21	Харилцагчийн үйлчилгээг сайжруулах, харилцагч нартаа мэдээлэл хүргэх сувгийг нэмэгдүүлэх зорилгоор BULL аппликэш нэвтрүүлэх төслийг эхлүүлсэн.	
	Байгаль орчин, нийгэм эдийн засгийн эрсдэлийн удирдлага:	
22	Эрсдэл хариуцсан нэгж нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эрсдэлийг “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороогоор хэлэлцүүлэн шаардлагатай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсэн.	
23	“Зээлийн бодлого”-д Байгаль орчин, нийгэм эдийн засагт ээлтэй байх стандартыг баримталж ажиллах, Монгол улсын хууль тогтоомжид хориглосон үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлсээр ирсэн нь бид үйл ажиллагаагаараа дамжуулан байгаль орчин, хүн ам, тэдгээрт хор хөнөөл учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорьж байна.	
24	Байгаль орчин, нийгэм, зохицуулалтын (БОНЗ) бодлогыг батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.	
25	Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын үйл ажиллагааны хүрээнд: ТоС холбооны гишүүн байгууллагын хувиар ТоС холбооноос зохион байгуулсан долоон удаагийн уулзалт, семинарт оролцсон.	
	Сургалт, хөгжүүлэлт чиглэлээр:	
26	Дасан зохицох хөтөлбөрийн хүрээнд “Шинэ ажилтны чиглүүлэх” сургалтыг 3 удаагийн давтамжтай 13 ажилтныг, 41 цагийн сургалтад хамруулсан.	
27	Харилцааг удирдах нь интерактив дотоод сургалтыг IV улиралд 2 удаагийн давтамжтай зохион байгуулж, нийт ажилтнуудыг бүрэн хамруулсан.	
28		Ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээний тухай дотоод сургалтыг нийт 5 удаагийн давтамжтайгаар компанийн нийт ажилтнуудад зохион байгуулсан.
29		Компанийн бүх ажилтны чадамжийн хүрээнд дотооддоо 2 удаагийн давтамжтай 8 цагийн танхимын сургалт, мөн ажлын байр тус бүрээр /мэргэжлийн/ мэргэшүүлэх 9 удаагийн 14 цагийн танхимын гадаад сургалтуудад ажилтнуудаа хамруулсан байна.

30		Сургалтын үр дүнг сайжруулах зорилгоор дотоод сургалтуудыг олон төрлийн арга, хэлбэр ашиглан явуулж буй бөгөөд BUZZER ROUND багаар хуваагдан оролцсон асуулт хариултын ур чадварын тэмцээн байв. Мөн хуваалцах соёлыг бэхжүүлэх, түгээх зорилготой “Туршлага хуваалцах өдөр” буюу салбар бүр өөрсдийн сайн туршлагаа бусдадаа хуваалцан, бусдаас нээлттэй суралцах боломжийг бүрдүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсаар байна.
31		Зөвхөн ажилтнуудад зориулсан холбоосоор дамжуулан аливаа журам зааврыг ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор “BULL Хүүгийн зөвлөмж” богино хэмжээний сургалтыг шаардлага үүсэх бүрт Бодит кейс дээр жишээ авч тайлбарлан, түүний дагуу асуулт, хэлэлцүүлгийг өрнүүлсэн.
Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр:		
32		Санхүүгийн зохицуулах хороо нь Дэлхийн Банкнаас хэрэгжүүлдэг “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн тухай код” (WeCode)-д нэгдэн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын дэмжлэг үзүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудыг онцлон сурталчлах зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгын хүрээнд 2025 оны 4-р сарын 16-ны өдөр зохион байгуулсан “We finance code буюу Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код”-ыг Монгол Улсад албан ёсоор нэвтрүүлж, олон нийтэд танилцуулах нээлтийн үйл ажиллагаанд оролцон тус кодоод албан ёсоор нэгдсэн.
33	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо 30 жилийн ой тохиож буйтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Азийн үнэт цаасны формын 30 дахь удаагийн чуулганыг 9-р сарын 11-13-ны өдрүүдэд Mongolian Capital Market Connectivity 2025” нэртэйгээр зохион байгуулсан арга хэмжээг Монгол улсын санхүү, хөрөнгийн зах зээлийг олон улсад сурталчлах талаас харж, дэмжин ажилласан.	
34	Санхүүгийн зохицуулах хорооноос иргэд олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, мэдлэг мэдээлэл түгээх чиг үүргийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын хэвлэл мэдээллийн төв, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, санхүүгийн салбарын 11 мэргэжлийн холбоодтой хамтран цахим залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах, иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх нэгдсэн арга хэмжээ “Хашир бай” аяныг дэмжин хамтран ажиллалаа.	
Нийгмийн хариуцлагын хүрээнд:		

	Жил бүр уламжлал болгон зохион байгуулладаг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.	
35	 2025.05.05-ны өдөр Эмэгтэй бизнес эрхлэгч харилцагч нартаа зориулан хувь хүний хөгжил, Бизнесийн удирдлага гэсэн үндсэн 2 агуулгын хүрээнд сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулав. Эхний хэсэгт Дэд Захирал Н.Оюунтунгалаг Санхүүжилт хэрхэн хүсэх, бизнесээ өргөжүүлэхэд юу шаардлагатай талаар сургалт орлоо. Сургалтын 2 дах хэсэгт “Ажил амьдралын тэнцвэр” сургалтыг Гэр бүлийн сэтгэл судлаач Г.Наранбаатартай хамтран явуулав. Энэхүү үйл ажиллагааг цаашид уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байна.	
36	 Ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд ажилтнуудаа хамруулдаг уламжлалтай. 5-р сард “Рехамед” эмнэлэг, Гялс төвтэй хамтран нийт ажилтнуудаа үзлэг, оношилгоонд хамрууллаа. Улмаар зонхилон тохиолдож буй хоол боловсруулах эрхтэний өвчлөл, түүний шалтгаан, хэрхэн сэргийлэх талаар Анагаах ухааны доктор (Ph.D) Т.Цэрэнтогтох эмчээс нийт ажилтнууддаа танхимын сургалт, зөвлөгөө авлаа.	
37	 Компанийн хамт олны уур амьсгал, соёлыг түгээх зорилготой нийт ажилтнуудыг хамруулсан зуны аялал арга хэмжээг зохион байгуулсан.	
38	 Эх үрсийн баярыг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гэр бүлийн өдөрлөг” дурсамж дүүрэн болж өндөрлөлөө. Энэ удаагийн өдөрлөгөөр хүүхдийн баяраа хамтатган тэмдэглэж, хүүхэд бүрт хүслийн бэлгийг гардуулан, олон төрөлт буухиа тэмцээнүүдийг зохион байгуулав.	

39		Бид нийгмийн хариуцлагын хүрээнд эх дэлхийгээ хайрлан хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулсаар ирсэн. Жил бүр хүмүүс ихээр зорчдог хэсэгт хог түүдэг энэхүү аяныг 2022 оноос эхлэн тасралтгүй 4 жил уламжлал болгон зохион байгуулж байна. Энэ удаагийн цэвэрлэгээг 2025 оны 6 сарын 21-ний өдөр Зүүн салаанд зохион байгууллаа.
40		Бидний ирээдүй болсон Өсвөр насны хүүхдүүдийн дунд томоохон сэдэв болоод буй “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг контент”-ыг нийгмэд эерэг зөв дадалыг түгээгч Хамтдаа суралцаж, хамтдаа хөгжье “Citta Mongolia” пэйжийн үүсгэн байгуулагч Сэтгэл зүйч Г.Наранбаатар, жүжигчин А.Ганчимэг нарын тус контентийг ивээн тэтгэж, хамтран ажилласан. Тус контентаар дамжуулан таны гаргаж буй жижиг буруу үйлдэл бусдад ямар их бие, сэтгэлийн гэмтэл учруулж болох асуудлыг хөндсөн.

Эрсдэлийн бодлого:

Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, төрийн зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэрийг анхааралтай ажиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажиллаж байна. Энэ хүрээнд өмнөх оноос хэрэгжүүлж эхэлсэн дараах шийдвэрүүдийг мөрдсөөр байна.

1. Төвлөрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг харилцагчид 300.0 сая төгрөгөөс дээш хэмжээний зээл олгохгүй байх,
2. Эдийн засгийн сектороор хязгаарласан зээлийн багцын хязгаарууд болон барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлогыг чангаруулах,
3. Уул уурхай, тээвэр, барилгын салбар болон эдгээр салбаруудтай хамаарал бүхий орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгохгүй,
4. Өр орлогын харьцаа болон зээл үнэлгээний харьцаа дээр зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлагыг ханган ажиллах,
5. Зээлийн мэдээллийн тухай хуульд 2025 оны 05-р сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг олон улсын стандарт, практикт нийцсэн FICO онооны системд бүрэн шилжүүлж, зээл олголтын шийдвэр гаргалтад шууд ашиглаж эхэлсэн. Улмаар харилцагчийн зээлд хамрагдах доод FICO онооны босгыг тогтоон, дотоод журамд тусган мөрдүүлснээр зээлийн чанар, эргэн төлөлтийн сахилга батыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн,

6. Харилцагч таньж мэдэх үйл ажиллагааг сайжруулах хүрээнд МОНПЕП ХХК-ийн sanction compliance программыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Тус системийг ашигласнаар хориг арга хэмжээний жагсаалт, өндөр эрсдэлтэй этгээдийг автоматаар илрүүлэх, хянах боломж бүрдсэн. Ингэснээр хууль, зохицуулалтын шаардлагыг хангах түвшин дээшилж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулсан.
7. Эрсдэлийн бодлогоор тодорхойлсон эрсдэлүүдийн хүрээнд улирал тутам эрсдэлийн тайлан боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороонд тогтмол танилцуулсан. Тайлангаар илэрсэн гол эрсдэлүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, бууруулах болон хянах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд эрсдэлийн удирдлагын үйл явц илүү зохион байгуулалттай болж, байгууллагын эрсдэлийг тасралтгүй хянах, сайжруулах боломж бүрдсэн.

Санхүүгийн үзүүлэлт:

Бид 2025 оны I, II, III болон IV-р улирлуудад Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны бүх шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байгаа ба 2022-2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд /сая.төг/	2022	2023	2024	2025	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	Аудитлагдсан	СЗХ-нд илгээсэн	2025/2024*
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,209.36	3,286.55	13,310.62	7,091.97	-47%
Нийт зээл	22,223.77	47,597.28	73,381.88	86,206.91	17%
Зээлийн эрсдэлийн сан	-124.27	-722.17	-945.12	-2,178.35	130%
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	626.34	1,515.54	1,751.23	2,421.38	38%
Бусад авлага	217.12	-	50.35	84.40	68%
Бусад хөрөнгө	40.65	296.74	2,512.25	4,972.04	98%
Үндсэн хөрөнгө	173.63	217.02	3,154.00	2,971.97	-6%
Нийт хөрөнгийн дүн	25,366.60	52,190.96	93,215.20	101,570.31	9%
Итгэлцэл, бусад өр төлбөр	16,314.43	33,686.93	64,950.18	61,428.40	-5%
Итгэлцэл	7,155.15	14,068.71	23,465.51	24,408.95	4%
Зээлийн эх үүсвэр	5,895.25	11,595.43	28,148.37	24,887.01	-12%
Бонд	2,200.00	5,600.00	12,047.16	10,720.62	-11%
Бусад өр төлбөр	1,064.03	2,422.79	1,289.14	1,411.83	10%
Дүрмийн сан	7,400.00	12,199.83	12,199.83	12,199.83	0%
Хуримтлагдсан ашиг	1,652.17	6,304.19	16,065.19	27,942.12	74%
Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн	25,366.60	52,190.95	93,215.20	101,570.35	9%
Хүүгийн орлого	4,109.23	13,399.17	24,063.67	31,551.82	31%
Хүүгийн зардал	963.16	5,122.17	9,979.00	12,769.34	28%
Цэвэр хүүгийн орлого	3,146.07	8,277.01	14,084.67	18,782.47	33%
Хүүгийн бус орлого	229.49	992.93	1,272.52	1,207.54	-5%
Хүүгийн бус зардал	1,390.35	1,381.86	3,014.89	4,082.52	35%
Эрсдэлийн сангийн зардал	124.27	597.89	223.87	1,233.68	451%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	1,860.94	7,290.19	12,118.43	14,673.82	21%
Ү/А-ны бус орлого		-	13.1	5.88	-55%
Ү/А-ны бус зардал	47.49	95.83	318.86	226.70	-29%
Татвар төлөхийн өмнөх ашиг	1,813.45	7,194.36	11,812.67	14,453.00	22%
Орлогын татварын зардал	184.09	890.34	2,051.67	2,576.07	26%
Цэвэр ашиг	1,629.36	6,304.02	9,761.00	11,876.93	22%



2025 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн гол үзүүлэлтийг 2024 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад нийт хөрөнгө 8.3 тэрбум төгрөг буюу 9%-иар, нийт зээлийн багц 12.8 тэрбум төгрөг буюу 17%-иар тус тус өссөн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 2.95% байна.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 22%-иар өсч 11.8 тэрбум төгрөгт хүрсэн.

“БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК
2026.01.20